



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 23 өдөр

Дугаар Б/103

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дүгээр зүйлийн 26.1, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тухай 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Д.Пүрэвжаргалыг 2017 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Мөрөн сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Д.Пүрэвжаргалын цалинг ТҮБД-н 6-ын 4 дүгээр шатлал /674244/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Д.Шинэгэрэл/-д зөвшөөрсүгэй.

3. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА